



НЭД-ын 2003 оны 29-р захирамжаар ~~...~~  
Хүчингүй

31

# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2003 оны 01 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Дүрэм, орон тоог батлах  
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолын 8 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Байгаль орчин, экологийн хяналтын газар"-ын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Байгаль орчин, экологийн хяналтын газрыг орлогч дарга 1, орон тооны хязгаарыг 49 хүртэл байхаар тогтоосугай.

Гурав. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан энэ оны эхний хагас жилд багтаан батлуулах ажлыг зохион байгуулахыг Байгаль орчин, экологийн хяналтын газар /Г.Бүдрагчаа/-т даалгасугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/61 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2001 оны 07 дугаар захирамжийн хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИН, ЭКОЛОГИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДҮРЭМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчин, экологийн хяналтын газар нь /цаашид "газар" гэх/ байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, экологийн тэнцлийг хангах талаар явуулж байгаа төрийн бодлогыг хотын нутаг дэвсгэр, ногоон бүсэд хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

1.2.Газрын үндсэн зорилт нь харъяалах нутаг дэвсгэр дэх байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, экологийн тэнцлийг хангахад чиглэгдэн боловсруулсан бодлогыг хэрэгжүүлэх энэ талаар гарсан Монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн биелэлтэнд хяналт тавьж ажиллана.

1.3.Газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Байгаль орчны багц хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжууд, төрөөс байгаль орчны талаар баримтлах бодлого Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тогтоол, шийдвэр, мөрийн хөтөлбөр энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.4.Газар нь Нийслэлийн Засаг дарга, орлогч, Тамгын газрын удирдлагад үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.5.Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг томилж, чөлөөлнө.

1.6.Газрын дарга нь эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргана. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

1.7.Газрын дарга нь нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр орлогч даргаа томилж, чөлөөлнө.

1.8.Газар нь үүрэг зорилтоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар газрын даргад зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг байгуулан ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батална.

1.9.Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.



## Хоёр. Газрын үүрэг

2.1. Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

2.2. Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах.

2.3. Байгаль орчны улсын хяналтыг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулж нийслэлийн нутаг дэвсгэрт экологийн тэнцлийг хангах, байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах бодлого боловсруулахад оролцох.

2.4. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон орон нутгийн хамгаалалттай газар, байгалийн үзэсгэлэнт, түүхийн дурсгалт газар, ховор ан амьтан, ургамлын хамгаалалтын байдалд хяналт тавих.

2.5. Нийслэл хот, ногоон бүсийн экологийн асуудалд эдийн засгийн арга хөшүүрэг, механизм хэрэглэх, байгалийн нөөц баялаг ашиглалтын төлбөр хураамж, үнэлгээг мөрдүүлэх, биелэлтийг хянахын зэрэгцээ хотын экологийн сангийн зарцуулалтыг төлөвлөхөд оролцож гүйцэтгэл гаргах.

2.6. Аж ахуйн үйл ажиллагаа явуулснаас болон бусад чиглэлээр байгаль орчинд үзүүлэх ачааллын талаар тогтоогдсон үндэсний болон олон улсын жишиг, хэм хэмжээг мөрдүүлэх.

2.7. Нийслэл хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө дагуул хотуудын төлөвлөлт, байршилт, сонголт, мөн шинээр байгуулах болон өргөтгөн шинэчлэх, тоноглох, үйлдвэр аж ахуйн нэгжийн барилга байгууламжийн зургийн даалгавар, техник эдийн засгийн үндэслэл зураг төсөлд экологийн магадлан шинжилгээ гаргуулж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх шаардлагыг хангуулах.

2.8. Шинээр байгуулах болон одоо ашиглаж буй үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх болон бусад хэлбэрээр байгалийн нөөц баялаг ашиглах аливаа төсөл, арга хэмжээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулах.

2.9. Улаанбаатар хотын ногоон бүсийн байгаль орчин, экологийн төлөв байдлыг тодорхойлох, байгалийн баялгийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй хөтөлбөр, төлөвлөгөө, төслийг холбогдох байгууллагатай хамтран боловсруулж хотын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын зөвлөл, Байгаль орчны сайдын зөвлөлийн хуралд оруулан шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

2.10. Хотын ногоон бүсийн байгалийн баялаг /ашигт малтмал, ан амьтан, ургамал, хөрс, ой мод, газар, ус гэх мэт/ түүний нөөц болон орчныг бохирдуулах эх үүсвэрийн тооллого, бүртгэл судалгаа гаргаж байгаль орчныг хамгаалах бодлого боловсруулахад ашиглуулах.



2.11.Цацраг идэвхит болон химийн бусад хортой бодис, нефть, хий, үйлдвэрлэлийн хаягдлыг тусгайлан хадгалах, булахад байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх.

2.12.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, улсын даалгавар, захиалгат ажлын биелэлтийг хангуулж гүйцэтгэлийг тогтоосон журмаар гаргуулах.

2.13.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг өргөн оролцуулж ардын уламжлалт зан үйлийг хөхүүлэн дэмжүүлэх, хүүхэд, залуучууд, хөдөлмөрчдийн экологийн боловсрол хүмүүжлийг дээшлүүлэх сурталчилгаа мэдээллийн ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах.

2.14.Газрын үйл ажиллагаатай холбогдсон санхүү, тайлан бүртгэл, материал, техникийн хангамж, хөдөлмөр хамгаалал нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

2.15.Эрхэлж буй ажлын хүрээнд хамаарах зайлшгүй шаардлагатай асуудлаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлэх.

2.16.Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулах.

2.17.Байгууллагын хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

### **Гурав.Газрын эрх**

3.1.Нийслэл, түүний ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа улс, хоршоолол, олон нийтийн болон аж ахуйн нэгж, иргэдээс байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг таслан зогсоож зохих журмын дагуу арга хэмжээ авах, буруутай байгууллага, аж ахуйн нэгж иргэд / түүний дотор гадаадын болон хамтарсан /-ийн үйл ажиллагааг тухайн зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох, хэрэв бүрмөсөн зогсоох шаардлагатай гэж үзвэл энэ тухай саналаа Байгаль орчны яам, Нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх.

3.2.Экологийн хувьд зөвшөөрч болохгүй үйлдвэр, цех, аж ахуйн нэгжийг шинээр байгуулахад хориг тавих.

3.3.Байгаль орчин экологийн төлөв байдлыг үнэлэх, хамгаалах, тодорхой асуудлаар магадлагаа гаргахад шаардагдах мэдээ баримт, судалгааг холбогдох байгууллага хүмүүсээс гаргуулж авах.

3.4.Хот дүүргийн төр захиргааны болон улс, хоршоолол, олон нийт, аж ахуйн нэгж /түүний дотор гадаадын болон хамтарсан албан байгууллагаас гаргасан шийдвэр/ -г гаргасан тогтоол, тушаал, захирамж, заавар, журам, аргачлал, техник технологийн шийдэл нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжид нийцэхгүй, байгальд сөрөг нөлөө үзүүлэхээр байвал түүний заалтыг хүчингүй болгуулах буюу өөрчлүүлэх тухай шаардах, дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

3.5. Хотын нутаг дэвсгэр, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, хамгаалах, экологийн тэнцлийг хадгалах талаар санал дүгнэлтээ Байгаль орчны яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тавих.

3.6. Байгаль хамгаалах хууль тогтоомжийг зөрчиж зөвшөөрөлгүй бэлтгэсэн мод болон байгалийн бусад баялаг, ангийн холбогдол бүхий хэрэгсэл, ангийн гаралтай арьс, бүтээгдэхүүнийг хураан авч улсын орлого болгох.

3.7. Байгалийн баялаг, газар ашигласны төлбөр, торгууль бусад хураамжаас хотын төсөвт орсон орлогоос байгаль хамгаалах арга хэмжээнд зориулж зарцуулах талаар саналаа Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх.

3.8. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг төр, засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагналд уламжлах, газрын шагналаар шагнах.

3.9. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн үзлэг шалгалт, илэрсэн зөрчил, дутагдалтай холбогдсон зураг авах, дүрс бичлэг хийх, шаардлагатай бол түүний хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчлах.

3.10. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль, тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх.